

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

МОНГОЛЫН ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН УЛС ТӨРИЙН ОРЧИН

Б.Галаарид*

* Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч, докторант

Түлхүүр үг: чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөө, олон ургальч үзэл

Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшлийн асуудлыг судлахад онцгой анхаарал хандуулах сэдэв бол улс төрийн орчин юм. Үүний тулд улс төр гэж юу вэ гэдгийг эхлээд тодорхойлох хэрэгтэй болно. Судлаачид “Улс төр гэж нийгмийн гишүүдийн саналын зөрүүтэй байдлаас үүдэн тусгай арга хэрэгсэлгүйгээр шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд нийгэмд хамтын шийдвэрийг гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажилагааг хэлнэ”¹ хэмээн үзсэн байна. Тэгэхээр 1989-1990 онд Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалыг нийт монголчуудын хамтын шийдвэр гэж үзэж болох бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарт хэрхэн нөлөөлсөн асуудлыг анхаарч судлах шаардлага байгаа юм.

Үзэл суртал, улс төрийн хатуу цагдан хяналт бүхий нийгмийн тогтолцооноос олон ургальч үзлийг эрхэмлэсэн чөлөөт нийгэм рүү шилжих шилжилтийн үе нь коммунист сэтгүүл зүйгээс ардчилсан чөлөөт сэтгүүл зүй рүү шилжих үйл явцтай давхацсан, өөр хувилбар байх боломжгүй үе байсан

бөгөөд энэ шилжилт улс төрийн аргаар хийгдсэн нь 1990-ээд оны эхэн үеийн үйл явцаас тодорхой байна.

1980-аад оны сүүлийн хагаст Монголын сэтгүүл зүйд урьд өмнө хаалттай байсан улс төрийн сэдвүүдийг хөндөх зэргээр олон ургальч үзэл илэрч эхэлсэн боловч энэ нь өргөн утгаар авч үзвэл социализмын сургаал номлолоос гажсан байдлыг засах, зөв замаар нь хөгжүүлэх эрмэлзэл тэмүүллийн хүрээнд л эргэлдэж байжээ. Олон жилийн хугацаанд бүрэлдэн бий болсон улс төр, эдийн засгийн систем, үзэл суртлын номлол үр дүнд хүрэхгүй нь тодорхой болоод байсан ч үүнийг засч залруулж өөрчлөх боломжтой системийн хямрал гэж харснаас эргэлт буцалтгүй сүйрэл гэж ухаарсан нь цөөхөн байжээ.

Нийгмийн тогтолцоог үндсээр нь өөрчлөх тухай ил тод яриа мэдэгдэл 1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд болсон МоАХ-ны анхдугаар цуглаанаас гарч эхэлсэн ч “Эдийн засгийн механизмыг хөдөлгөгч гол хүч болох социалист зах зээлийн концепцыг боловсруулан”², “Социалист гурван хэм хэмжээ буюу шударга ёс, тэгш эрх, эрх чөлөөг нийгмийн амьдралын бүх хүрээнд эрхэмлэх”³-ийг уриалж байсан

нь улс төрийн шинэ хүчнүүдийн байр суурь ч эхэндээ социализмын алдааг залруулах тухай итгэл үнэмшилд суурилж байсныг харуулж байна.

Гэхдээ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтуудыг хэрэгжүүлэх, “хэвлэлийн эрх чөлөөг баталгаатай болгох”⁴, “Улс төр, олон нийтийн бүх байгууллагыг чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх эрхээр хангах”⁵ зэрэг шаардлагуудыг анхнаасаа дэвшүүлэн тавьж байсан нь чөлөөт хэвлэлийн тогтолцооны суурь хөрсийг бүрдүүлэх, чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний тухай тулгуур ойлголтыг Монголын улс төрд оруулж ирэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаар нийтлэг шийдвэр гаргах хөрсийг бүрдүүлж, тэр нь 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд тус улсын иргэн нь “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх”, “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”⁶ хэмээн тусч, иргэдийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан дараа дараагийн хуулиуд гарах суурь нөхцөл болж өгчээ.

Энэ үеийн Монгол орны улс төрийн дүр зургийг тодорхойлохдоо судлаач Д.Чулуунжав “1990-1992 оны хооронд шилжилтийн шинжтэй төр, засаг Монгол оронд оршин байсан ба харин 1992 оны эцэс рүү шинэ, ардчилсан Үндсэн хуулийн дагуу чанарын хувьд цоо шинэ төрийн байгууламжийг бүтээж буй болгосон юм”⁷ гэсэн байна. Энэхүү төрийн тогтолцооны өөрчлөлт

чөлөөт хэвлэл хөгжих таатай нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлсөн бөгөөд доктор М.Зулькафилийн тэмдэглэсэнчлэн “Аливаа өөрчлөлтөд хамгийн түрүүнд өртөж, шинэ сэргэг зүйлийг мэдрэх чадвар, боломжоороо сэтгүүл зүй нийгмийн бусад институтээс давуу байдаг онцлогтой”⁸ нь энэ удаад батлагдаж, нийгмийн амьдралд хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөө гүнзгийрч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо ч эрс нэмэгджээ. Энэ зурвас үед Монголын хэвлэл мэдээллийн салбарт хэвлэлийн эрх чөлөөний либертари онол хэрэгжих улс төрийн таатай нөхцөл бүрэлдсэн байна.

Энэ нь ХҮII-ХҮIII зуунд хэвлэлийн салбар дахь авторитаризмын эсрэг тэмцэгчдийн баримталж байсан чөлөөт хэмээх үг жинхэнэ утгаараа үйлчилдэг, ямар ч хориг саадгүй сэтгүүл зүйг бий болгох эрмэлзэлтэй нэн төстэй үзэгдэл байжээ. Үүний үр дүнд хэвлэл мэдээллийн салбар нийгмийн эрх ашигт үйлчлэх таатай нөхцөл бүрдэж, нийгмийн шинэ тогтолцоон дахь мэдээллийн засаглалын үе эхэлсэн нь тухайн цаг үеийн чөлөөт хэвлэлийн хөгжилд нөлөөлсөн улс төрийн эерэг орчин болж байжээ.

Доктор Б.Болд-Эрдэнэ “Мэдээллийн засаглал нь ардчилсан нийгмийн нэг гол онцлог төдийгүй түүний хөгжлийн амин чухал асуудал билээ. Энэ нь төр засгийн бодлогод хяналт тавих, нийгмийн янз бүрийн үзэл бодол, байр суурийг чөлөөтэй илэрхийлэх, бүлгүүдийн зөвшилцөлд үйлчлэх явдал юм”⁹ гэж мэдээллийн засаглалыг тодорхойлсон байна. Тэгвэл 1990-ээд оны эхэн хагас, тодруулбал Монголд чөлөөт хэвлэлийн

тогтолцооны үндэс бүрэлдсэн үеийн олонх хэвлэл мэдээлэлд аливаа төрлийн цагдан хяналт харьцангуй бага үйлчилж, иргэдийн янз бүрийн үзэл бодол, байр суурийг чөлөөтэй нийтэлж, бүлгүүдийн зөвшилцлийг хангаж чадаж байжээ.

Харин төрийн мэдлийн цөөн тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд төрийн байгууллага, албан тушаалтны хөндлөнгийн оролцоо нэлээд хүчтэй байж, мэдээлэл олж авах боломж, хөрөнгө санхүүгийн чадавхийн хувьд чөлөөт хэвлэлүүдээс харьцангуй давуу байдалд оршиж байсан бөгөөд тухайн үед энэ нөхцлийг судлаачид “Гарааны тэгш бус байдал”, “Улс төрийн шууд оролцоо” зэргээр нэрлэн томъёолж байсан байна.

1988 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу Монголын төр, засаг 1999 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн мэдлийн монополь хэвлэлүүд болох “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” зэрэг сониноо татан буулгасан ч орон нутгийн төр захиргааны байгууллагын мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Засаг даргын Тамгын газрын харьяанаас гарч, ИТХ-ынхаа мэдэлд очигдоосон нь төрийн мэдэлд хэвээр үлдсэн хэрэг бөгөөд энэ нь чөлөөт хэвлэлийн хөгжилд тухайн үеийн улс төрийн орчин сөргөөр нөлөөлж байсны бодит илрэл мөн.

Мэдээллийн хамгийн хүчирхэг суваг болох Үндэсний радио, телевизийг Монголын төр өөрийн мэдэлд 2006 оны долдугаар сарын 1-ний өдрийг хүртэл, өөрөөр хэлбэл Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийг зөрчин найман жил байлгаж чадсан нь улс төрийн орчин чөлөөт хэвлэлийн хөгжилд сөргөөр нөлөөлж байсны нэг жишээ мөн.

Хэвлэл мэдээллийн салбарынхан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дээдлэгчдийн удаа дараагийн шахалт шаардлагын үр дүнд 2005 оны нэгдүгээр сарын 27-нд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг УИХ-аар баталсан нь чөлөөт хэвлэлийг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах үйлсэд олсон том ололт болсон байна. Гэхдээ уг хуулийн 3 дугаар

«

Төрийн мэдлийн цөөн тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд төрийн байгууллага, албан тушаалтны хөндлөнгийн оролцоо нэлээд хүчтэй байж, мэдээлэл олж авах боломж, хөрөнгө санхүүгийн чадавхийн хувьд чөлөөт хэвлэлүүдээс харьцангуй давуу байдалд оршиж байсан

»

зүйлийн 1-д “Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн”¹⁰ гэж заасан боловч тус байгууллагын удирдах дээд байгууллага болох Үндэсний зөвлөлийн 15 гишүүний 4-ийг нь Монгол Улсын Ерөнхийлөгч, 7-г нь Улсын Их Хурал, 4-ийг нь Монгол Улсын Засгийн газар нэр дэвшүүлэн УИХ-д өргөн мэдүүлж (Хуулийн 21-ийн 5; 21-ийн 7), нэр дэвшсэн хүмүүсийг УИХ хэлэлцэн томилох (Хуулийн 21-

ийн 8) заалт оруулсан нь олон нийтийн радио телевизийн үйл ажиллагаа нь хараат бус байх (Хуулийн 4-ийн 1) үндсэн зарчимд нь харшилсан, улс төрийн дээд түвшний оролцоог хуулиар баталгаажуулж өгсөн үйлдэл болсон бөгөөд энэхүү хууль өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Мөн удирдах дээд байгууллага болох Үндэсний зөвлөлийн санхүүгийн хараат бус байдлыг баталгаажуулж өгөөгүй учраас Гүйцэтгэх удирдлагаас хараат болж мэдэх нөхцлийг үүсгэж байгаа нь энэ хуулийн сул тал юм.

Улс төрийн орчин Монголд чөлөөт хэвлэлийн тогтолцоо хөгжин бэхжихэд зарим талаар түлхэц өгсөн ч зарим талаар чөдөр тушаа болж байгаа нь хэвлэл мэдээллийн салбар өдий хүртэл хууль эрх зүйн бүрэн зохицуулалтгүй байгаа, 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль түүхэн үүргээ гүйцэтгэсэн бөгөөд илүү нарийвчилсан хуулийн зохицуулалт хэрэгтэй байна гэдгийг хаа хаанаа хүлээн зөвшөөрдөг ч хууль санаачлах эрх бүхий субъектүүд болох Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ-ын гишүүдээс өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн гурван төсөл УИХ-ын гурван удаагийн сонгуульт хугацаа дамжин батлагдахгүй байгаа, заримыг хууль санаачлагч нь буцаан татсанаас тодорхой байна.

Улс төрийн амьдралд төлөөллийн ардчиллын зарчим үйлчилдэг Монгол Улсын хувьд чөлөөт хэвлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх асуудал улс төрийн орчноос хамгийн ихээр

хамааралтай ч хэвлэлийн бүрэн эрх чөлөөг хуулиар баталгаажуулах улс төрийн эр зориг дутмаг, ардчиллын амин сүнс болсон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх улс төрийн соёл тэр бүр хэвшээгүй зэрэг нөхцөл шалтгааны улмаас сүүлийн арав гаруй жилд олигтой ахиц дэвшил гараагүй байна.

Ишлэл

¹ *Цанжид А.* 2010. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., х. 7.

² МАХН-ын Төв хорооны VII бүгд хурал, БНМАУ-ын Ардын их Хурлын VIII чуулганд МоАХ-ны цуглаанд оролцогсдоос өргөн барих бичиг. УБ., 1989.XII.10.

³ Ардчилсан социалист хөдөлгөөнөөс Монголын ард түмэнд хандаж гаргасан тунхаг. УБ., 1990.I.04.

⁴ МоАХ-ны өргөн барих бичиг. “Б”-гийн 4-р заалт. 1989.12.10.

⁵ АСХ-ний тунхаг. 1990.01.04.

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 2015. х. 13.

⁷ *Чулуунжав Д.* 2007. Монгол дахь либералчлал ба ардчиллын онол, практикийн тулгуур асуудлууд. УБ., х. 49

⁸ *Зулькафиль М.* 1997. Монголын орчин үеийн сэтгүүл зүй. УБ., х. 15.

⁹ *Болд-Эрдэнэ Б.* 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ., х. 80.

¹⁰ <http://www.legalinfo.mn/law/details/424>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Болд-Эрдэнэ Б.* 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ.

2. *Зулькафиль М.* 1997. Монголын орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

3. *Цанжид А.* 2010. Улс төрийн шинжлэх ухаан. УБ.

4. *Чулуунжав Д.* 2007. Монгол дахь либералчлал ба ардчиллын онол, практикийн тулгуур асуудлууд. УБ.